

АРДЫН ХУВЬСГАЛЫН 60 ЖИЛ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛ ТҮҮНИЙ ГОЛ ҮР ДҮН

БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч
академич **Б. Ширэндэв.**

Монголын ард түмэн 1981 оны долдугаар сард Ардын Хувьсгалын 60 жилийн ойг ёслол тэмдэглэх гэж байна.

Хувьсгалын өмнөх Монгол олон зуун жил феодалын харилцаа ноёрхсон орон байлаа. Тэр харилцаа нь юуны өмнө феодалууд газар ба малыг бүрэн өмчилж, хамжлагын ардуудыг хагас өмчилж дарлан захирч байснаар илэрч байв. Феодалын өмчийн зэрэгцээгээр ардын өмч-мал байсан, тэд хошуу ноёны билчээр нутагт малаа адуулдаг байв.

Феодалуудын аж ахуй нь хамжлага ардуудаас татвар, гувчуур хураан, тэдний үнэ хөлсгүй хөдөлмөрийг мөлжин баяжиж, хамжлага ардуудын аж ахуй нь улам бүр үгүйрэн хоосорсоор байжээ. Ингэж нэг талаас гадаадын мөнгө хүүлэгчид, булаан эзлэгчдээр дэмжүүлсэн монголын феодалууд, нөгөө талаас малчин ардуудын хооронд нийгмийн ангийн гүн гүнзгий зөрчилдөөн хурцдах эдийн засгийн бодит шалтгаан илэрдэг байжээ.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний ба хувьсгалт хөдөлгөөн нь дэлхийн үйл явдалтай, ялангуяа хөрш Орос орон дахь хувьсгалт хөдөлгөөнтэй авцалдан нэгдэж байж сая бүрэн амжилтанд хүрч чадах байв.

Малчин ардууд Д.Сүхбаатар, Х.Чойбалсан нарын зэрэг хувьсгалт ардчилсан төлөөлөгчдийнхөө тусламжтайгаар Октябрийн хувьсгалын үзэл санааг анх удаа ард олон өөрийн хүчээр өөрсдийн төлөө хийсэн хөдөлмөрчдийн хувьсгалын үзэл санаа мөн гэж ухамсарласан байна.

Дэлхийн империализм, түүнд янз бүрээр гар хөл бологсдын эсрэг тэмцэх нийтлэг бодит зорилгоор нэгдсэн Зөвлөлт Орос, Монгол орны хөдөлмөрчдийн харилцан нийцсэн эрх ашиг нь монгол-зөвлөлтийн ард түмний хооронд төрийн хэмжээнд ангийн холбоо байгуулж бэхжүүлэхэд хүргэсэн юм.

Октябрийн аугаа их социалист хувьсгалын хувьсгалжуулагч үзэл санаа өргөмж нөлөөн дор монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь улам бүр феодал, империализмыг эсэргүүцсэн ангийн шинж чанарыг олж, урьд үзэгдээгүй их эрч хүчтэй өсөн бэхжижээ. Энэ нь монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хийсэн тэмцэл амжилттай болох, Ардын хувьсгал ялах, хоцрогдмол Монгол орон капитализмыг алгасан социализмд шилжин ороход хамгийн тохиромжтой нөхцөлийг бий болгосон юм.

Энэ нь бас Октябрийн социалист хувьсгал дэлхийн хөгжлийн бүхий л явцад гүн гүнзгий нөлөөлөх зүй тогтолтойг дахин нотолсон билээ.

В.И.Ленин хэлэхдээ, Их Октябрийн олон улсын ач холбогдол түүний сүр хүчийг хоёр талаас нь авч үзэх хэрэгтэй гэсэн бөгөөд нэгдү-

гээрт, дэлхийн түүхийн бүхий л явцад уг хувьсгалын үзүүлсэн хийгээд үзүүлсээр байгаа нөлөө, түлхэцийн үүднээс авч үзэх, хоёрдугаарт бусад аливаа хувьсгалд уг хувьсгалын гол үндсэн зүй тогтлууд гарцаагүй давтагдах талаас нь авч үзэх ёстой юм гэжээ.

Империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал нь монголын ард түмэнд эрх чөлөө, төрийн тусгаар тогтнол авчирч, улс орныг социализмд хүргэсэн билээ.

1921 оны Ардын хувьсгалын гол зорилго нь ард түмэн улсын засгийн эрхийг байлдан авах явдал байв. Энэ зорилго нь намын анхны программчилсан баримт бичиг, тэрчлэн ард олны зэвсэгт бослогын байгууллага болсон ардын Түр засгийн газрыг байгуулсан тэрхүү үйл явдалд тодорхой тусгалаа олсон юм. Ардын хувьсгалын ялалтын дараагаар ардын Түр засгийн газар нь байнгын засгийн газар болж, тус орон бүрэн эрхт ардын ардчилсан Бүгд Найрамдах улс болж хөгжсөн юм.

Зовлонд нэрвэгдсэн Монгол оронд ардын хувьсгал ялснаар бүрэн эрхт Монгол улс цаашдаа дэлхийн социалист системийн нэгдмэл гэр бүлийн болон НҮБ-ын гишүүн болох сайхан боломжтой болсон юм.

Иймд Монгол ардын хувьсгал нь Октябрийн социалист их хувьсгалаар эхлээд одоо эрчимтэй өрнөж буй дэлхийн нийт хувьсгалт үйл явдлын бүрэлдэхүүн хэсэг болсон юм.

II

К. Маркс, Ф. Энгельс нар хоцрогдсон орнууд капитализмыг алгасан феодализмаас социализмд шилжин орж хөгжиж болох тухай асуудлыг анх дэвшүүлэн тавьжээ.

В.И.Ленин түүхийн шинэ нөхцөлд К. Маркс, Ф. Энгельс нарын тэрхүү үндэслэлийг улам хөгжүүлж, тухайлбал 1920 онд Коминтерний II их хурал дээр тавьсан илтгэлдээ «...хоцрогдсон орнууд тэргүүний орны пролетарийн тусламжтайгаар зөвлөлт байгуулал ба хөгжлийн тодорхой шатыг дамжиж, капиталист хөгжлийн шатыг алгасан коммунизмд хүрч чадна»¹ гэж заажээ.

Монгол орон капитализмыг алгасан социализмд шилжихдээ хоёр гол шатыг дамжсан юм. Үүнд: 1921 оноос 1940 он хүртэл үргэлжилсэн ардчилсан шат, 1940 оноос 1961 он хүртэл үргэлжилсэн социалист шат тус тус байлаа. Энэхүү дурдан буй хөгжлийн шатууд нь шийдвэрлэсэн нийгэм эдийн засгийн асуудлын эрэмбэ дараа, ач холбогдлоор бие биеэсээ ялгаа бүхий тодорхой үеүдтэй байсан нь мэдээж.

Монгол орон капиталист биш замаар хөгжин социализмд шилжихтэй холбогдуулан ардын хувьсгалын ардчилсан шатанд нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэсэн нь түүний империализм, феодализм, капитализмыг эсэргүүцсэн шинжээр тодорхойлогдож байна.

Төрөөс ангийг баримталсан бодлого хэрэгжүүлж, албан татварын системийг хөдөлмөрчдийн тусын тулд ашигласнаар ард ангийн зарц ядуу хэсгийн материаллаг байдлыг мэдэгдэхүйц сайжруулж, ардуудын үндсэн гол хэсгийн аж ахуйн таваарлаг шинжийг дээшлүүлж, энэ аж ахуйн салбарт капиталист элементүүдийг хязгаарлаж чадсан юм.

МАХН, ардын төр нь аж үйлдвэр, тээвэр, худалдаа, санхүү-зээлийн систем зэрэг улс ардын аж ахуйн чухал салбарт хөрөнгөтний элементүүдийг шургалуулахгүй байх бодлогыг тууштай явуулжээ. Энэхүү туршлага нь одоо улс орныхоо капиталист биш хөгжлийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө тэмцлийг манлайлж буй хувьсгалт хүчний анхаарлыг татаж болох юм.

¹В. И. Ленин. Зохиолууд. УБ. 1967 он, 31-р боть, 230-р тал

Дөчин он гэхэд аж үйлдвэр санхүү-зээлийн систем, худалдаа, холбоо, тээвэрт социалист сектор баттай тогтжээ.

Ардын хувийн аж ахуйтны дотор хөдөө нутагт аж ахуйг эрхлэн хөтлөх социалист хэлбэрийг нэвтрүүлэх явдалд сангийн аж ахуй зэрэг улсын хөдөө аж ахуйн газрууд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Хувьсгалын анхны шат дуусах үе буюу өөрөөр хэлбэл, 1930-аад оны сүүлч гэхэд феодалын анги устгагдаж, гадаадын, гол төлөв хятадын олон тооны худалдаа мөнгө хүүлэх капитал улс орноос бүрмөсөн шахагдан гарсан билээ. Энэ үеэр нийгмийн шинэ хүчин-үндэсний ажилчин анги бүрэлдэн тогтов.

1959 он гэхэд ардын аж ахуйтныг хоршооллож дууссанаар улс орны амьдралын бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцаа ялсан юм.

Монголын ард түмэн намынхаа удирдлагаар нийгмийн амьдралын бүх талыг ардчилан социалист ёсоор өөрчлөн байгуулахын төлөө ангийн ширүүн тэмцэл явуулж, түлхэн унагаагдсан феодал ангийн улайрсан эсэргүүцэл, империализм, милитаризм, жанжлах үзэлтнүүдийн зүгээс төрийн тусгаар тогтнолд заналхийлж байсан аюулыг даван туулаад монгол нутагт социализмыг бүтээн байгуулсан юм.

Нам марксист-ленинист онолыг удирдлага болгон, Зөвлөлтийн Дундат Азийн ард түмэн социализмд шилжсэн баялаг туршлагад түшиглэн, өөрийн орны түүх, эдийн засаг, ахуй байдлын онцлогийг харгалзан 1928-1932 онуудад баруун оппортунистууд, зүүний нугалаатнуудын гаргасан ноцтой алдаа завхралыг зоригтой, эрс шийдэмгий засч улс орноо социализмд хүргэж чадсан юм.

Монгол орон капиталист шатыг алгасан капиталист биш хөгжлийн замаар социализмд шилжин хөгжих зорилтыг амжилттай шийдвэрлэсэн гол чухал нөхцөл гэвэл:

-БНМАУ олон улсын коммунист хөдөлгөөн, дэлхийн анхны социалист Зөвлөлт улсын ах дүүгийн тусламж, дараа нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудад түшиглэсэн явдал юм.

МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю.Цэдэнбал тэмдэглэхдээ, В.И.Ленин, Д.Сүхбаатар нарын үндэслэн байгуулж, бидэнд өвлөн үлдээсэн монгол-зөвлөлтийн найрамдал нь нөлөөлөх хүчин чадлынхаа хувьд монголын ард түмний аз жаргал, цэцэглэлт хөгжилтийн ширгэшгүй эх булаг бөгөөд энэ найрамдал нь дундад зууны хоцрогдлоос социализмд шилжих асар том үсрэлт хийх бололцоог ардын эрхт Монгол улсад олгосон юм гэжээ.

Дэлхийн социалист систем, олон улсын коммунист хөдөлгөөнд капиталист биш зам сонгосон орнууд түшиглэх нь найдвартай баталгаа мөн болохыг шинэ залуу улсуудын капиталист биш хөгжлийн орчин үеийн практик дахин нотлон харуулсаар байна. Социалист хамтын нөхөрлөлийн орнууд, олон улсын коммунист хөдөлгөөн нь империализм колоничлол, шинэ маягийн колоничлолын эсрэг энх тайвны төлөө явуулж буй тууштай тэмцлээрээ колоничлолын дарлалаас ангижирсан ба социалист чиг баримжааны зам сонгож авсан орнуудад үнэлж баршгүй их тусламж үзүүлж байна.

-Монгол Ард улс социализмд шилжин хөгжих явдлыг марксист манлай -МАХН-ын зүгээс улс төрийн талаар удирдаж буй явдал.

Империализм, капитализмын эсрэг, түүнчилэн дотоодын нийгэм эдийн засгийн асуудлыг марксизм-ленинизмийн сургаалд түшиглэсэн хувьсгалт манлайлагчийн удирдлагагүйгээр шийдвэрлэх бололцоогүй гэдгийг Монголын туршлага, орчин үеийн практик ахин дахин нотолж байна.

-Улс орныг социалист ёсоор өөрчлөн байгуулах явцад ажилчин ангийн диктатур болон дэвшсэн ардын ардчилсан засаг төр байгаа явдал.

Хувьсгалт ардчилсан үзэлтнүүд хөдөлмөрчдийн засгийг байгуулж, бэхжүүлэхдээ Монголын ардын ардчилсан төрийн туршлагыг харгалзан үзэж болох нь дамжиггүй.

-Нийгэм-эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийг удирдахад өргөн олон түмнийг татан оролцуулсан явдал.

-Эдүгээ ажилчин анги байхгүйгээр социалист чиг баримжаагаар хөгжин эхлэж буй оронд ардын ардчилсан төрийн нөхцөлд бүрэлдэн тогтоод, цаашдаа социалист нийгмийн зонхилох гол хүч болсон манай ажилчин ангийн түүхэн замнал, туршлагыг тодорхой хэмжээгээр сонирхон үзэж болох юм.

Түүнчилэн ардын хувьсгалын хөдөлгөгч хүчин нь болсон малчин ардууд эхлээд хамжлагаас чөлөөлөгдөж, дараа нь социализм байгуулах явцад ажилчин ангийн холбоотон болсон тэр жишээ нь өөрийн улс орныг социалист чиг баримжаагаар хөгжүүлэхийн төлөө тэмцэгчдийн хувьд мөн анхаарал татаж болох юм.

Социалист соёлын хувьсгалын явцад ардын сэхээтэн бүрэлдэн тогтов.

Соёлын хувьсгал нь хүн амын бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь арилгаж, ардын боловсрол гэгээрлийн системийг буй болгох, эрүүлийг хамгаалах, гэгээрүүлэн боловс-руулах газруудыг байгуулах, шинжлэх ухаан, соёл, урлаг, утга зохиол хөгжүүлэх зэрэг нийгмийн олон асуудлыг бас шийдсэн билээ.

Соёлын хувьсгалын явцад ард олны материалын ба соёлын түвшин, ухамсар дээшлэхийн хирээр, шинжлэх ухаан-шашингүйн суртал нэвтрүүлгийн нөлөөн дор хүн амын сүсэг бишрэл нь урьдын улиг болон арилжээ.

Марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчим бүхий социалист үзэл суртал тус оронд батжив.

Ажилчин анги хоршоолсон ард, ардын сэхээтний холбоо БНМАУ-ын улс төрийн үндсийг бүрэлдүүлж байна.

Улсын ба хоршооллын хоёр үндсэн хэлбэр бүхий үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх социалист өмч БНМАУ дахь нийгмийн эдийн засгийн үндсийг бүрэлдүүлж байна.

БНМАУ-ын улс ардын аж ахуй нь социалист аж үйлдвэр, хоршоолсон хөдөө аж ахуй, тээвэр, холбоо, худалдаа болон бусад салбараас бүрдэж байна. Тус улсын эдийн засгийн бүрэлдэхүүн хэсэг нь тус бүр дотроо тодорхой салбаруудтай. Аж үйлдвэрийн нэн чухал салбарууд гэхэд: түлш-эрчим хүч, уул уурхай, барилга, хөнгөн ба хүнсний үйлдвэр болж байна.

Социалист хөдөө аж ахуй нь мал аж ахуй, газар тариалан хоёр томоохон салбараас бүрдэнэ.

60-аад оны эхнээс манай орон хөгжлийнхөө шинэ шатанд орсон юм. Энэ шатны үндсэн зорилтыг 1966 онд хуралдсан намын XV их хурлаар баталсан МАХН-ын Программ тодорхойлсон юм. Тус баримт бичигт улс орноо цаашид үйлдвэржүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг механикжуулах, улс ардын аж ахуйн бүх салбарын техник хангамжийн түвш- нийг дээшлүүлж социализмын материал техникийн бааз байгуулан дуусгаж, БНМАУ-ыг ойрыи ирээдүйд аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгох явдал манай орны хөгжлийн шинэ шатны эдийн засгийн гол зорилт мөн гэж тэмдэглэжээ.

МАХН өөрийн шинэ программын заалтыг хэрэгжүүлж одоо хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг тогтмол дээшлүүлэх үндсэн дээр социализмын материал-техникийн бааз байгуулахад ард түм-

нийхээ тэмцлийг чиглүүлж байна. БНМАУ энэ бүх асуудлыг шийдвэрлэх үйлсдээ шинэ шинэ амжилт олсоор байна.

Манай орон дэлхийн шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглах үндсэн дээр, улс ардын аж ахуйн бүхий л салбарыг бүх талаар нь эрчимтэй хөгжүүлэх болон тэдгээрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, тус орныг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон аажмаар хувиргаж байна.

Одоо тус орны аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийлсэн нийлбэр бүтээгдэхүүний 60 гаруй хувь, үндэсний орлогын 27 хувь нь аж үйлдвэрт оногдож байна. 1979 оны мэдээгээр үзвэл, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1940 оныхтой харьцуулбал, даруй 39 дахин өсчээ. 1980 онд манай аж үйлдвэр нийгмийн нийт бүтээгдэхүүний 41 хувийг үйлдвэр-лэж байв.

БНМАУ-ын хөдөө аж ахуй нь том том сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн хоршоолол нэгдлүүд болжээ. Одоо сангийн аж ахуй бүр 360 мянган гектар газар, 10 мянган гектар тариалангийн талбай, бараг 30 мянган толгой малтай байна. Хөдөө аж ахуйн нэг нэгдэлд дунджаар 335 мянган гектар газар нутаг, 70 гаруй мянган толгой мал, хэдэн арван трактор, аатомашин зэрэг хөдөө аж ахуйн бусад техник оногдож байна.

Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнууд улсын зүгээс ихээхэн дэмжлэг авч, үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг боловсронгуй болгож, шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг нэвтрүүлж байна. Мөн тэргүүний агротехникийг нэвтрүүлэх замаар үр тарианы ургацыг дээшлүүлэх талаар олон арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Манай улсын хүн ам эдүгээ мах, сүү, талх, төмс, ногоо болон эх орны үйлдвэрлэлийн хүнсний бусад төрлийн бүтээгдэхүүнээр хангагдаж байна.

Социалист бүтээн байгуулалтын нэг бүрэлдэхүүн хэсэг бол намынхаа удирдлагаар манай ард түмний хэрэгжүүлсэн соёлын хувьсгал юм.

Монголын хүн ард сонин сэтгүүл, уран сайхны ба шинжлэх ухаан-техникийн зохиол бүтээлийг төрөлх хэл дээрээ унших төдийгүй, эх орны ба гадаад орны зохиогчдын бичсэн өөр хэл дээрх бүтээлийг уншиж байна. Номын сан, клуб, радио нэвтрүүлэг, телевиз кино үзвэрийн газрууд манай хүн ардад үйлчилж байна. Сургуулийн насны бүх хүүхэд хөдөөд заавал анхан шатны, хотод дунд шатны боловсролтой болох явдал амжилттай хэрэгжив.

Бүрэн дунд боловсролтой залуус дотоод, гадаадын их, дээд сургуулиудад дэвшин суралцаж, төрөл бүрийн мэргэжлээр өндөр мэргэшил эзэмшиж байна.

Ардын урлагийн арвин баялаг сан хөмрөг, дэлхий дахины тэргүүний соёлын ололтоос сурч эзэмших үндсэн дээр үүсэн буй болж, хөгжиж байгаа манай утга зохиол, урлагийн мандал бадрал нь шинэ Монгол орны 60 жилийн хөгжлийн маш чухал үр дүн мөн. Шинжлэх ухаан мөн түргэн хөгжиж байна.

БНМАУ-ын ШУА-ийн системд болон яам, албан газруудын дэргэдэх эрдэм шинжилгээний институт, их, дээд сургуулиудад нийгэм, байгаль, техникийн ухааны салбараар шинжилгээ судалгаа хийж байна.

Монголын эрдэмтэд математик, физик, хими, биологи, геологи, техник, философи, эрх зүй, эдийн засаг, хэлбичгийн ухааны салбарт эрдэм шинжилгээний тодорхой амжилтанд хүрч байна. Сансарын судлалаар ч мөн тийм байна.

Удахгүй болох МАХН-ын XVIII их хурал БНМАУ-ыг хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орноос аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон хувиргахад чиглэгдсэн шинэ шинэ зорилтыг төлөвлөн заах болно.

ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон жинхэнэ найрамдал, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа нь манай улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн асуудлыг амжилттай шийдвэрлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж ирсэн ба гүйцэтгэсээр байна.

Монгол-зөвлөлтийн хамтын ажиллагаа нь бүх талыг хамарсан шинжтэй бөгөөд ЗХУ-ын Коммунист Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нөхөр Л.И.Брежнев тэргүүтэй зөвлөлтийн нам засгийн төлөөлөгчдийн 1966 оны нэгдүгээр сард БНМАУ-д хийсэн найрамдлын айлчлалын үеэр гарын үсэг зурсан манай хоёр орны хоорондын Найрамдал, Хамтын ажиллагаа, Харилцан туслах тухай Гэрээний дагуу жил дутам шинэ шинэ агуулга, хэлбэрээр улам баяжиж байна. ЗСБНХУ болон ЭЗХТЗ-ийн бусад орны хамтын хүчээр барьж байгуулсан аж үйлдвэрийн шинэ төвүүд-Дархан, Чойбалсан, Эрдэнэт бол чухамхүү ах дүү улсуудын үр ашигтай хамтын ажиллагааны яруу тод жишээ мөн.

БНМАУ тийнхүү ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудтай өргөн дэлгэр хамтран ажилладаг юм. Олон улсын хөдөлмөрийн социалист хуваарь болон интеграцид тус улс идэвхтэй оролцож байгаа нь үндэсний аж үйлдвэр болон тус орны үйлдвэрлэх хүчнийг хурдацтай хөгжүүлэх, түүний экспортын бололцоог нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Бодит социализмын хөгжлийн зүй тогтолт үйл явц нь социалист эдийн засгийн интеграцийн Цогцолбор Программыг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх, мөн нийгэм, эдийн засгийн амьдралын бүх салбарт социалист хамтын нөхөрлөлийн орнуудыг ойртуулан нягтруулах замд шинэ чухал шат үе болж байна.

БНМАУ-ын засгийн газар, Монголын ард түмэн ЗХУ болон Варшавын гэрээнд оролцогч бусад улсын байнгын тууштай энх тайванч санаачлага бүрийг сайшаан дэмжиж, даян дэлхийн энх тайвныг бэхжүүлэх, зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг хазаарлах, Азийн аюулгүй байдлын төлөө, дайны аюул заналын эсрэг гуйвалтгүй тэмцэж байна.

БНМАУ-ын энхийг эрхэмлэсэн бодлого нь энэ газар Дэлхий дээр энх амгалан байдлыг ханган бэхжүүлэх, нийгэм-эдийн засгийн янз бүрийн байгуулал бүхий орнуудын хооронд хамтын ажиллагаа хөгжүүлэх, олон улсын ажилчин анги, мөн Ази, Африк, Латин Америкийн болон даян дэлхийн хөдөлмөрчидтэй интернационалч эв санааны нэгдлээ бататгахад бүрэн чиглэдэг юм.

МОНГОЛЬСКАЯ НАРОДНАЯ РЕВОЛЮЦИЯ И ЕЕ ГЛАВНЫЕ ИТОГИ

(Р е з ю м е)

Президент АН МНР, академик
Б. Ширендыб

В начале своей статьи автор показывает, что накануне народной революции в условиях раздробленности и колониальной эксплуатации страны резко ухудшалось ее экономическое положение, жизнь трудового аратства становилась все более тяжелой. Вместе с тем он подчеркивает, что под революционизирующим идейным воздействием

Великой Октябрьской социалистической революции, с невиданной силой росло и крепло, национально-освободительное движение монгольских аратов приобрело все более антифеодальный и антиимпериалистический классовый характер. Это и создало самые благоприятные условия для успеха борьбы монгольского народа за свою свободу и независимость страны,

Победа Монгольской Народной революции 1921 года, свершилась под руководством МНРП, при помощи и поддержке пролетариата Советской России, в условиях перехода человечества от капитализма к социализму. Именно с победой Народной революции многострадальная Монголия получила счастливую возможность развиваться как самостоятельное свободное государство и перейти к строительству социализма, минуя капитализм. Монгольская Народная революция, говорится в статье, явилась составной частью общего и ныне бурно развивающегося. Мирового революционного процесса, начатого Великой Октябрьской социалистической революцией.

По мнению автора, переход Монголии к социализму минуя капиталистическую стадию развития, осуществлялся двумя этапами: демократическим с 1921 по 1940 г. и социалистическим с 1940 по 1961 г.

В статье подчеркивается, что наш народ под руководством своей партии, ведя решительную классовую борьбу демократические и социалистические преобразования всех сторон общественной жизни несмотря на ожесточенное сопротивление свергнутого класса феодалов, угрозу государственной независимости со стороны империализма, милитаризма и гегемонизма построит социализм на монгольской земле.

Автор считает, что главными условиями успешного решения задач развития Монголии, минуя капиталистическую стадию, явились:

-опора МНР на международное коммунистическое движение и на братскую помощь первого в мире Советского социалистического государства, на страны социалистического содружества;

-политическое руководство со стороны марксистского авангарда МНРП:

-наличие народно-демократической власти, ставшей в ходе социалистических преобразований страны диктатурой рабочего класса;

-привлечение широких народных масс к решению социально-экономических проблем и управлению обществом;

-оформление народной интеллигенции в ходе социалистической культурной революции и др.

С начала 60-х годов МНР вступила в новый период своего развития. Задачи этого периода, как указывается в статье, определены Программой МНРП, принятой XV съездом в 1966 г.

МНРП, осуществляя свою новую Программу, направляет борьбу своего народа на создание материально-технической базы социализма на основе постоянного повышения производительности труда и эффективности общественного производства. В решении этих проблем МНР достигает новых и больших успехов. Путем всемерной интенсификации всех отраслей народного хозяйства и повышения их экономической эффективности на основе использования мировых достижений науки и техники. Она постепенно превращается в индустриально-аграрную страну.

В заключение автор отмечает, что правительство МНР и монгольский народ, поддерживая последовательные мирные инициативы СССР и других государств Варшавского договора, неизменно выступают против военной опасности, за укрепление мира и безопасности в Азии и во всем мире, а также за развитие делового сотрудничества со всеми странами мира, за укрепление интернациональной солидарности с международным рабочим классом и трудящимися Азии, Африки и Латинской Америки.